



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Албан томилолтын зардал гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дахь заалт, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Үйлдвэрлэл, технологийн паркуудын засаглалыг сайжруулах, бүтэц зохион байгуулалтыг судлах, паркуудын үйл ажиллагаатай танилцан туршлага солилцуулахаар Инженер Б.Батбилэгийг Багануурын үйлдвэрлэл, технологийн паркт, Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн Г.Пүрэвдоржийг Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркт томилон ажиллуулсугай.

2. Албан томилолтоор ажиллах ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Инженер, мэргэжилтнүүдийн ажил үүрэгт зохицуулалт хийж, 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрийн хооронд 3 хоногийн албан томилолтыг зохион байгуулж ажиллахыг Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэнд даалгасугай.


4. Албан томилолтоор явсан ажлын тайланг буцаж ирснээс хойш ажлын 2 хоногт багтаан илтгэх хуудсаар тайлагнахыг Маркетинг, олон нийтийн харилцаа хариуцсан мэргэжилтэн Э.Энгүүнд үүрэг болгосугай.

5. Албан томилолтод шаардагдах 1000000 (нэг сая) төгрөгийн зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч /Г.Ганцэцэг/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА  С.БАТЖАРГАЛ



Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,  
технологийн парк” ОНӨААТҮГазрын даргын  
2021 оны 12 сарын 13-ны өдрийн 114 тоот  
тушаалын 1 дүгээр хавсралт.



**БАГАХАНГАЙ, БАГАНУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ**

**Арга хэмжээний зорилго:** Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Үйлдвэрлэл инновацыг цогцоор нь хөгжүүлэх ажлын хүрээнд орон нутагт байршсан ижил төстэй Багануур, Багахангайн үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагаатай танилцах, паркуудын засаглалыг сайжруулах, үйл ажиллагаатай танилцах

**Очих газар:** Багануурын үйлдвэрлэл, технологийн парк, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк

**Улс, хот, аймаг, нэр:** Улаанбаатар

**Сум, дүүргийн нэр:** Багануур, Багахангай дүүрэг

**Хугацаа:** 2021 оны 12 дугаар сарын 14-нөөс 17-ны өдрийг хүртэл

**Ажиллах өдөр:** 3 /ажлын хоног/

**Ажлыг хэрэгжүүлэх албан хаагч:**

№	Овог нэр	Албан тушаал
Багануурын үйлдвэрлэл, технологийн парк		
1	Б.Батбилэг	Инженер
2	Б.Ариунбилэг	Хуулийн мэргэжилтэн
3	Б.Гансүх	Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн
Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк		
4	Г.Пүрэвдорж	Бүтээн байгуулалт хариуцсан мэргэжилтэн
5	Э.Энгүүн	Маркетинг ОНХХ хариуцсан мэргэжилтэн
6	Х.Бямбаа	Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

**Хийгдэх ажлууд**

№	Хийгдэх ажлын товч агуулга
1	Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаатай танилцах, харилцан туршлага солилцох Төсөв: 1,000,000 /нэг сая/ төгрөг

Налайхын барилгын материалын үйлдвэрлэл,  
технологийн парк” ОНӨААТҮГазрын даргын  
2021 оны 12 сарын 13 -ны өдрийн А/14 тоот  
тушаалын 2 дугаар хавсралт

ОНӨААТҮГ

ТТЭ0051-4 5690683

БАГАХАНГАЙ, БАГАНУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАХ ТОМИЛОЛТЫН ТӨСӨВ

№	Албан хаагч	Хоног	Унаа	Хоол	Байр	Нийт
1	Б.Батбилэг	3	49500	30000	261500	
2	Б.Ариунбилэг	3	49500	30000		
3	Б.Гансүх	3	49500	30000		
4	Г.Пүрэвдорж	3	49500	30000	261500	
5	Э.Энгүүн	3	49500	30000		
6	Х.Бямбаа	3	49500	30000		
Нийт дүн			297,000	180,000	523,000	1,000,000